



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 4/149

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Ойн тухай хуулийн 13.1.22, 13.1.21, 13.1.27 дэх хэсгийн заалт, "Ойн талбайн байршил, норматив батлах тухай" Засгийн газрын 2012 он 255, 2016 оны 79 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ойн ангийн үлгэрчилсэн дүрэм"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Дээрх дүрмийг Сум дундын болон сум дүүргийн ойн анги, аймаг нийслэлийн байгаль орчин аялал жуулчлалын газруудад хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ойн бодлого зохицуулалтын газрын дарга / М. Тунгалаг/-т үүрэг болгосугай.

САЙД



Н. ЦЭРЭНБАТ

000010113

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 03 дугаар сарын 09 ны өдрийн
1149 дугаар тушаалын хавсралт

ОЙН АНГИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрмийн нийтлэг зорилго нь Ойн тухай хуулийн 8.3, 13.1.22, 13.1.27 дахь заалтыг хэрэгжүүлж Сум дундын болон сумын ойн ангийн /цаашид "Ойн анги" гэх/ эрхлэх ажил, үйлчилгээний чиглэл болон удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх зэрэгтэй холбогдох харилцааг хууль тогтоомжид нийцүүлэн тогтооход оршино.

1.2. Ойн анги нь Ойн тухай хуулийн 18.3 дугаарт заасан эрх үүргийн хүрээнд Ойн баялгийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн тогтвортой менежментийн нэгдсэн бодлогыг мэргэжлийн, мэргэшлийн түвшинд орон нутагт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүждэг, төрийн ажил үйлчилгээ эрхлэх орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар мөн.

1.3. Ойн анги нь хариуцаж буй ойн сангийн хэмжээ, ашиглалтын нөөц, ойн төрлөөс хамаарч дор дурдсан хэлбэртэй байна.

1.3.1. Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар / цаашид "ОНӨТҮГ" гэх /, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 15 дугаар зүйл/

1.3.2. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /цаашид "ОНӨААТҮГ" гэх / "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 15 дугаар зүйл/

1.4. Шилмүүст төрлийн ойн нөөцийн менежментийг хариуцаж Ойн ангийг ОНӨААТҮГ- н хэлбэрээр ажиллуулах чиглэл баримтлах бөгөөд Ойн анги нь үйл ажиллагаандаа Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай", "Төсвийн тухай хууль", "Хөдөлмөрийн тухай" хууль, "Ойн тухай" хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, энэхүү дүрмийг мөрдөж ажиллана.

1.5. "Ойн анги" ОНӨТҮГ/, ОНӨААТҮГ/-ыг "Төсвийн тухай" хуулийн 58.2.13, 58.4.6, 58.5, Ойн тухай хуулийн 17.1.6, Засгийн газрын 2012 оны 7 дугаар сарын 25 ны өдрийн "Ойн талбайн байршил, норматив батлах тухай" 255 дугаар тогтоолыг үндэслэн Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний дагуу аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр байгуулж аймгийн Засаг даргын багцад төсвийг суулгаж өгнө.

ХОЁР. ОЙН АНГИЙН ОНООСОН НЭР, БАЙРШИЛ

2.1. Ойн ангийн оноосон бүрэн нэр нь сум дахь ... аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын харьяа "Сум дундын болон сумын Ойн анги" орон нутгийн төсөвт төрийн өмчит үйлдвэрийн газар байх ба товчилсон нэр нь "....." /ОНӨТҮГ/, /ОНӨААТҮГ/ байна.

2.2. Ойн ангийн газрын оршин байгаа газар нь: Монгол улс, аймаг, сум

2.3. Ойн ангийн шуудангийн хаяг: Монгол улс, аймаг /
шуудангийн индекс/ сум.

ГУРАВ. ОЙН АНГИЙН БЭЛГЭДЭЛ, ТЭМДЭГ

3.1 Ойн анги нь өөрийн бэлгэдэл /эмблем/-тэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

3.2 Бэлгэдэл /эмблем/-ийн загварыг Ойн ангийн дарга баталж, Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд түүнийг хэрэглэх эрхийг үйлдвэрийн газар эдэлнэ.

3.3 Тэмдгээр үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

3.4 Тэмдгийг ойн ангийн дарга буюу даргын итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

ДӨРӨВ. ОЙН АНГИЙН ЗОРИЛТ, ЭРХЛЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ

4.1. Ойн ангийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь ойн баялгийн нөөцийг судлан тогтоож хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх Ойн аж ахуйн арга хэмжээ явуулах, тогтвортой менежментийн нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, ойн санг гэрээгээр иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах, ойн санд учирсан хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ хийх, ойн хөнөөлт шавж, өвчний голомтын тойм судалгаа хийж дүгнэлт гаргах, ойн төлөв байдалд үнэлгээ өгөх, ойн тооллого, бүртгэл, зохион байгуулалт, хөнөөлт шавж, өвчний тэмцлийн ажлын явцад хяналт шинжилгээ хийх, ойжуулалт, ойн аж ахуйн болон ойн ашиглалтын арга хэмжээний шинэ техник, технологийг турших, нутагшуулах, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах, бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулах, бусад шаардлагатай мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд оршино.

4.2. Сум дундын болон сумын ойн анги нь Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь заалт болон дараах ажил үйлчилгээг эрхэлнэ:

4.2.1 Ойн сангаас бэлтгэж байгаа модон материалд гарал үүслийн гэрчилгээ, эрхийн бичиг олгох, мод бэлтгэх гэрээ байгуулах, дагалт баялаг, ургамал, амьтны гаралтай түүхий эдийн ашиглалт, борлуулалтад хяналт тавина.

4.2.2. Модны үр, тарьц, бэлтгэх ажлыг зохион байгуулах, мод үржүүлгийн газрын үйл ажиллагаа эрхлэх, тарьц суулгац худалдаалах,

4.2.3. Ой зохион байгуулалтын материалыг үндэслэн нөхөрлөл, аж ахуйн нэгжийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, зөвлөгөө өгөх;

4.2.4. Аймаг сумын түвшинд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар явуулж буй бодлогыг хэрэгжүүлэх, Ойн санд байршин амьдардаг зэрлэг ан амьтадыг хамгаалах, өсгөн үржүүлэх ажлыг хариуцах, улсын ойн санд таримал ойг хүлээн авах;

4.2.5. Нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойд цэвэрлэгээ, арчилгаа хийсэн, бэлтгэсэн модны хэмжээг тогтоох, хэрэглэгчдэд нийлүүлэх, зах зээлд гаргах, модны захын үйл ажиллагаанд мэргэжлийн болон технологийн хяналт тавих;

4.2.6. Байгаль орчны тухай болон Ойн хууль, ой түүний дагалт баялаг, биологийн төрөл зүйлийг тогтвортой ашиглах хамгаалах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжид заасан үүргээ гүйцэтгэхэд нь сумын Засаг даргад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, гэрээ байгуулж ажиллах;

4.2.7. Ойн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаар хууль тогтоомжид заасан журмын дагуу ажил, үйлчилгээ эрхлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;

4.2.8. Ойн дагалт баялгийн цаг хугацааны судалгааг хийх, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх хэмжээг тогтоох;

4.2.9. Ойн хөнөөлт шавж, өвчний голомтын тойм судалгаа хийж дүгнэлт гаргах, ойн төлөв байдалд үнэлгээ өгөх, ойн тооллого, бүртгэл, зохион байгуулалт, хөнөөлт шавж, өвчний тэмцлийн ажлын явцад хяналт шинжилгээ хийх;

4.2.10. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх сургалт сурталчилгаа явуулах, нөхөрлөл аж ахуйн нэгж, иргэдэд ой хээрийн түймрийн менежментээр зөвлөгөө өгөх, түймэр унтраах ажиллагаанд нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах;

ТАВ. ОЙН АНГИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Ойн анги нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна. Үүнд:

5.1.1. Монгол улсын хууль тогтоомж болон энэхүү дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах;

5.1.2. Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн маркетинг, менежментийн үр ашигтай, оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

5.1.3. Эрхэлсэн асуудлаараа хууль тогтоомжийн хүрээнд гадаад, дотоодын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах, гэрээ, хэлэлцээр байгуулах, мэдээлэл солилцох;

5.1.4. Дүрэмд заасан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх зорилгоор салбарын өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах;

5.1.5. Сумын ойн санд судалгаа хийх, ашиглалтын болон төслийн санал боловсруулахад мэргэжлийн хүмүүс, холбогдох байгууллагатай нь зөвшилцөн гэрээний үндсэн дээр оролцуулах;

5.1.6. Батлагдсан бүтэц, зохион байгуулалт, орон тооны хүрээнд боловсон хүчнийг ажилд авах, чөлөөлөх;

5.1.7. Өөрт олгогдсон үл хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглах;

5.1.8. Ойн анги нь үндсэн хөрөнгийг орон нутгийн орон нутгийн өмчийн асуудал хариуцсан байгууллагаас олгосон эрх хэмжээний дотор захиран зарцуулах;

5.1.9. Ойн анги нь үндсэн хөрөнгийг зөвхөн орон нутгийн өмчийн төлөөлөгчийн шийдвэрийг үндэслэн аймаг сумын ИТХурлын шийдвэрээр данснаас хасах буюу борлуулах, устгах эрхтэй;

5.1.10. Хууль тогтоомжийн дагуу өмч хөрөнгө олж авах, аж ахуйн үйл ажиллагаа явуулах.

ЗУРГАА. ОЙН АНГИЙН УДИРДЛАГА

6.1. Ойн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.2.8 дахь хэсгийн заалтын дагуу Сум дундын Ойн анги нь аймгийн байгаль орчны газрын харьяанд ажиллана.

6.2. Сум дундын Ойн ангийн даргыг Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.8 дэх хэсэгт заасны дагуу Аймгийн Засаг дарга Байгаль орчны газрын даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх бөгөөд дор дурдсан мэргэжлийн шаардлага хангасан хүнийг Сум дундын Ойн ангийн даргаар томилно.

6.2.1. ойн чиглэлийн мэргэжилтэй, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй

6.2.2. ой болон байгаль орчны салбарт нэгээс доошгүй жил ажилласан туршлагатай

6.2.3. Удирдаж байсан хуулийн этгээдээ дампууруулсан, удирдах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс уг албан тушаалаас өөрчлөгдөж байгаагүй;

6.2.4. Байгууллагын үйл ажиллагаатай холбогдох чиглэлээр ашиг сонирхлын зөрчилгүй байх.

6.3. Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7 дахь хэсгийн заалтын дагуу байгуулагдсан Сумын Ойн ангийн даргыг тухайн сумын Засаг дарга тухай аймгийн Байгаль орчны газрын харьяанд ажиллаж байгаа өөрийн сумын нутаг дэвсгэр харьяалагдаж байгаа Сум дундын Ойн ангийн даргатай зөвшилцөн томилно.

Сумын Засаг дарга нь Сумын Ойн ангийн даргад нэр дэвшүүлж, зөвшилцөхдөө энэ журмын 6.2 –д заасан шалгуурыг харгалзан үзнэ.

6.4. Энэ журмын 6.3-т заасан сумын Ойн анги байгуулагдсан тохиолдолд нутаг дэвсгэрийг нь харьяалах Сум дундын Ойн анги нь тухайн сумын Ойн ангийн санхүү, дотоод үйл ажиллагаанд оролцохгүй байх зарчим баримтлан мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдамжаар ханган ажиллаж, ойн санг нь бүрэн хариуцуулж, үйл ажиллагааны үр дүнг нь сум дундынхаа Ойн ангийн нэгдсэн тайланд авч тусган мэдээлнэ.

6.5. Ойн ангийн дарга нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол түүнийг ажлаас чөлөөлөх үндэслэл болно.

6.6. Ойн ангийн даргын дэргэд зөвлөх үүрэг бүхий зөвлөл ажиллаж болно. Зөвлөлд аймаг, сумын "ИТХ"-н гишүүд, байгаль орчны чиглэлийн албан тушаалтан, нөхөрлөл, нөхөрлөлүүдийн холбооны төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөлөл орж болно.

6.7. Сум дундын ойн ангийн дарга нь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга болон аймгийн Засаг даргатай, сумын ойн ангийн дарга нь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга болон сумын Засаг даргатай гэрээ байгуулан ажиллах бөгөөд гэрээнд ойн ангийн даргын эрх, үүрэг, хариуцлагын хэм хэмжээ, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

6.8. Ойн ангийн дарга нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна:

6.8.1. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйлдвэрийн газрын дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

6.8.2 Сум дундын болон сумын ойн ангийн дарга нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж байгаа үйлдвэрийн газрын хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

6.8.3 Үйлдвэрийн газрын эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан ажиллах;

6.8.4 Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан үйлдвэрийн үйл ажиллагааны болон бизнесийн нууцыг чанд хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

6.8.5 Аймгийн болон сумын төрийн байгууллагаас баталсан удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдгэртэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх;

6.8.6 Ойн ангийн шинээр худалдан авах болон ақталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг орон нутгийн өмчийн асуудал хариуцсан байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

6.8.7. Ойн ангийн дарга нь олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, үйлдвэрийн газрыг төлөөлөх зэргээр үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах

6.9. Ойн ангийн дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

6.10. Ойн ангийн дарга өөрийн эрх, үүргийг орон нутгийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж итгэмжлэлийн үндсэн дээр холбогдох албан тушаалтанд түр шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

6.11. Ойн анги байршиж байгаагаас бусад харьяаллын сумдад мод модон материалын гарал үүслийн гэрчилгээ, эрхийн бичиг олгох, ойн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ойн нөхөрлөл болон бусад байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх үүрэг бүхий Ойн ангийн Байнгын төлөөллийг заавал томилон ажиллуулж, иргэдэд чирэгдэлгүй, хүнд сурталгүй үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулна.

ДОЛОО. ОЙН АНГИЙН ХЯНАЛТ

7.1. Ойн анги нь үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг Ойн ангийн дарга батална.

7.2. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулна.

7.3. Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалт болон санхүүгийн үйл ажиллагаанд орон нутгийн өмчийн хорооны холбогдох газраас хяналт тавьж ажиллана.

7.4. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт, шалгалтыг нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ.

НАЙМ. ОЙН АНГИЙН САНХҮҮЖИЛТ, САНХҮҮ, БҮРТГЭЛ, ТАЙЛАН

8.1. Ойн ангийн орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ:

8.1.1. Аймгийн засаг даргын багцад суусан орон нутгийн төсөв;

8.1.2. Гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хандив, тусламж, хандивлагч орнуудын зээл, буцалтгүй тусламж;

8.1.3. Ажил, үйлчилгээнээс олсон орлого;

8.1.4. Хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад эх үүсвэр.

8.2 Ойн анги нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

8.3. Ойн ангийн санхүүгийн тайлангийн үнэн зөвийг дарга, нягтлан бодогч хариуцна.

8.4 Сум дундын ойн ангийн дансанд байгаа мөнгийг Сум дундын ойн ангийн байрлаж байгаа сум төвлөрүүлэн хуваарилах эрхгүй

8.5 Ойн ангийн санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12-р сарын 31-ний өдөр дуусгаар болно.

8.6 Ойн ангийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг сонгон ажиллуулж болно.

ЕС. ОЙН АНГИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

9.1. "Сум дундын болон сумын Ойн анги" нь санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

- 9.1.1 Баланс;
- 9.1.2 Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;
- 9.1.3 Мөнгөн гүйлгээний тайлан;
- 9.1.4 Өмчийн өөрчлөлтийн тайлан;
- 9.1.5 Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин шагнал, урамшуулал;
- 9.1.6 Нэмэлт тайлбар;
- 9.1.7 Санхүүгийн тайлангийн тодруулга;
- 9.1.8 Хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон бусад мэдээлэл;
- 9.2 Ойн ангийн дарга нь Ойн судалгаа хөгжлийн төв, аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газар, аймаг сумын Засаг даргын тамгын газарт үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, зарцуулсан хөрөнгө санхүү, үр дүнгийн талаар тодорхой тусгасан тайланг хагас бүтэн жилээр гаргаж хүргүүлнэ;
- 9.2.1 Тайлангийн хугацаанд үйлдвэрийн газрын эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт;
- 9.2.2 Тайлангийн хугацаанд үйлдвэрийн газрын албан тушаалтан, ажиллагчдад олгосон шагнал урамшил, удирдлагын зардлын хэмжээ;
- 9.3 Шаардлагатай бусад мэдээлэл, тайлбар.

АРАВ. ОЙН АНГИЙН БИЧИГ БАРИМТЫГ ХАДГАЛАХ

- 10.1 Ойн анги нь дараах бичиг баримтыг хадгална.
- 10.1.1 Ойн анги нь дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, ойн ангийг байгуулах тухай холбогдох газруудын шийдвэр, тогтоол, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээ сертификатууд;
- 10.1.2 Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангууд, түүнд хийгдсэн аудитын дүгнэлт, зөвлөмжүүд;
- 10.1.3 Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримтууд;
- 10.1.4 Үйлдвэрлэл, технологи, норм норматив, түүнтэй холбогдох дүрэм, журам, заавар, холбогдох бусад баримт бичгүүд;
- 10.1.5 Хурлын тэмдэглэл, шийдвэр, захирлын гаргасан тушаал, шийдвэрүүд;
- 10.1.6 Бусад ач холбогдол бүхий баримт бичгүүд.
- 10.2 Дээрх бичиг баримтыг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах архивд шилжүүлэх зэрэг ажлыг Ойн ангийн бичиг хэрэг хариуцсан ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.


АРАВ НЭГ. ОЙН АНГИЙГ ТАТАН БУУЛГАХ

- 11.1 Сум дундын болон сумын Ойн ангийг Ойн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний дагуу аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр татан буулгана.

АРВАН ХОЁР. БУСАД

12.1 Энэхүү дүрэмд тусгагдсанаас бусад асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохицуулна.

12.2 Ойн ангийн дүрэм нь Монгол Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно.



Ойн бодлого зохицуулалтын газар

